



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/196

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", 29.1.5.-ын "а", Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дах заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 05 сарын 08-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг харгалзан Хатгал тосгоны Эмэгтэйчүүдийн зөвлөлд 2,532,500 төгрөг, ОХУ-ын Түнхэн аймгийн төлөөлөгчдийн хоолны зардалд 180,000 төгрөг, зочид, иргэдэд олгосон нутгийн бренд бүтээгдэхүүний зардалд 8,461,800 төгрөг, "Эрхэмсэг хадагтай" НҮТББ-д 1,500,000 төгрөг, аймгийн Сүсэгтний холбоонд 400,000 төгрөг, нийт 13,074,300 төгрөгийг төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс, эрүүл мэнд болон амьдралын аргагүй байдлыг нь харгалзан Улаан-Уул сумын иргэн Б.Чимгээд 100,000 төгрөг, Мөрөн сумын иргэн Г.Хишигсүрэнд 50,000 төгрөг, Ханх сумын иргэн Я.Дамдинжавд 1,200,000 төгрөг, Улаан-Уул сумын харьяат Монгол Улсын харцага Г.Элбэгийн эмчилгээний зардалд 500,000 төгрөг, Мөрөн сумын иргэн Г.Энхболдод 500,000 төгрөг Улаанбаатар хотод зохион байгуулсан арга хэмжээний зардалд 2,299,720 төгрөг, нийт 4,649,720 төгрөгийг Засаг даргын Ерөнхий дансны ангилагдаагүй бусад арга хэмжээний зардлаас тус тус зарцуулсугай.

2. Дээрх 17,724,020 (Арван долоон сая долоон зуун хорин дөрвөн мянга хорин) төгрөгийн 13,074,300 (Арван гурван сая далан дөрвөн мянга гурван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д, 4,649,720 (Дөрвөн сая зургаан зуун дөчин есөн мянга долоон зуун хорин) төгрөгийг Засаг даргын Ерөнхий дансны ангилагдаагүй бусад арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.ГАНБОЛД